



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2022 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтууд, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2022 оны үйл ажиллагааны орлогын төсвийг 64,879,468.900.0 (жаран дөрвөн тэрбум найман зуун далан есөн сая дөрвөн зуун жаран найман мянга есөн зуун) төгрөгөөр тогтоож нэгдүгээр хавсралтаар, зарлагын төсвийг 64,643,366.900.0 (жаран дөрвөн тэрбум зургаан зуун дөчин гурван сая гурван зуун жаран зургаан мянга есөн зуун) төгрөгөөр тогтоож хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 4,257,300.000.0 (дөрвөн тэрбум хоёр зуун тавин долоон сая гурван зуун мянга) төгрөгөөр тогтоож гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу захиран зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг ШУТИС-ийн захирал (Б.Очирбат)-д даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2022-2023 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтад суралцагчдын сургалтын нэг кредитийн төлбөрийг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

2. Магистрантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.4 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

3. Докторантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

4. Бизнесийн ахисан түвшний сургууль, Инженерийн ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын төвийн сургалтын нэг кредитийн төлбөрийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн дундаж үнэлгээг магистрантурт 1.4, докторантурт 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.


5. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

6. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэлээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

7. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тооцохдоо энэхүү тогтоолын 1-6 дахь заалтуудын үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

8. 2022-2023 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 3.000.000 (гурван сая) төгрөгөөр, бүрэлдэхүүн ШУТИС-Коосен технологийн коллежийн сургалтын төлбөрийг 3.300.000 (гурван сая гурван зуун мянга) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 2.000.000 (хоёр сая) төгрөгөөр тогтоосугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13 -ны өдрийн 40 дугаар тогтоолын хавсралт



**ШУТИС-ИЙН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
МӨРДӨХ НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ**

Д.Д	СУРГУУЛЬ	Хөтөлбөрийн ангилал	Нэг кредитийн үнэлгээ төгрөгөөр		
			2022/23 оны хичээлийн жилд элссэн оюутан	2019/20, 2020/21, 2021/22 оны хичээлийн жилд элссэн оюутан	2018/19 оны хичээлийн жил түүнээс өмнө элссэн оюутан
1	БАРИЛГА АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	Инженер, технологи	138,016	105,056	95,325
2	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
3	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
5	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ		138,016	105,056	97,616
7	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	Нийгмийн ухаан	134,976	102,742	100,416
8	ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ	Хэрэглээний шинжлэх ухаан	120,536	91,750	83,489
9	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		79,300	79,300	86,035
10	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ		120,536	91,750	87,689
	ДУНДАЖ		107,040		



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Оюутны байрны төлбөр тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилд мөрдөгдөх оюутны байрны төлбөрийг нэгдүгээр, оюутны байранд амьдардаг айл, ерхийн байрны төлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Оюутны байрны орчин, нөхцөлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал Б.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ
ОЮУТНЫ БАЙРНЫ ТӨЛБӨР**

Д.д	Оюутны байр	Өрөөний багтаамж, зориулалт	Сарын төлбөрийн хэмжээ мян төг	
			Нэг оюутан	Оюутнаас авах барьцаа (жилд)
1	Оюутны I байр (ҮТС)	4 хүний /дотоод оюутан/	80.0	30.0
		1 хүний люкс /гадаад оюутан, мэргэжилтэн/	264.0	30.0
		2 хүний люкс /гадаад оюутан, мэргэжилтэн/	234.0	30.0
		2 хүний энгийн /гадаад оюутан, мэргэжилтэн/	216.0	30.0
2	Оюутны III байр (БУХС)	2 хүний	95.0	30.0
		4 хүний	80.0	30.0
3	Оюутны IV байр (МХТС)	4 хүний	80.0	30.0
4	Оюутны V байр (МехТС)	4 хүний	70.0	30.0
5	ДТС-ийн оюутны байр	4 хүний	70.0	30.0

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13. -ны өдрийн 11 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ОЮУТНЫ БАЙРАНД АМЬДАРДАГ АЙЛ, ӨРХИЙН ТӨЛБӨР

№	Оюутны байр	Өрөөний багтаамж /м2/	Нэг өрхийн сарын төлбөрийн хэмжээ (мян төг)				
			түрээс	цахилгаан	дулаан, халуун ус, цэвэр ус, бохир ус	хог	нийт төлбөр
1	Оюутны III байр (БУХС)	12	170.0	20.0	30.0	2.0	222.0
		18	188.0	20.0	30.0	2.0	240.0
2	Оюутны IV байр (МХТС)	18	120.0	20.0	30.0	2.0	172.0
		36	188.0	20.0	30.0	2.0	240.0
3	Оюутны V байр (МТС)	9	108.0	20.0	30.0	2.0	160.0
		12	170.0	20.0	30.0	2.0	222.0
		18	188.0	20.0	30.0	2.0	240.0
		24	240.0	20.0	30.0	2.0	292.0



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Харьяа хүрээлэнгийн талаар авах арга хэмжээний тухай


Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.4, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7 дугаар заалт, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 299 дугаар тогтоол, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Засгийн газрын 2021 оны 299 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүрэлдэхүүн Ой модны сургалт, судалгааны хүрээлэн, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа хүрээлэнгүүд болгон өөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтцийг 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ой модны сургалт судалгааны хүрээлэн, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнг улсын бүртгэлд бүртгүүлэх, бүтцийг батлах, удирдлагыг томилох, өмч, эд хөрөнгийг тус хүрээлэнгүүдийн балансад шилжүүлэн бүртгэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан шийдвэрлүүлэхийг ШУТИС-ийн захирал Б.Очирбатад даалгасугай.

3. Харьяа хүрээлэнгүүдийн судалгаа, боловсруулалтын ажлын улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх, судалгааны чанар, үр өгөөжийг боловсронгуй болгоход чиглэсэн их сургууль-хүрээлэнгийн хамтын ажиллагааг оновчтой зохион байгуулж ажиллахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбатад даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН БҮТЭЦ

